



**ТӨВ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**
(жилийн эцсийн байдлаар)

Үнэлгээг баталгаажуулсан:

**Төсвийн Ерөнхийлөн захирагч
Төв аймгийн Засаг дарга**

.....

(Л.Төмөрчөдөр)

Хяналт, шижилгээ үнэлгээ хийсэн:

**Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ,
үнэлгээний хэлтсийн дарга**

.....

(Ц.Ариунбаяр)

Төлөвлөгөөг тайлагнасан:

**Төсвийн Шууд захирагч
Худалдан авах ажиллагааны
газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч**

.....

(Б.Ганхуяг)

2024.12.13

2024.12.13

Зуунмод

[illegible]

ТӨВ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(жилийн эцсийн байдлаар)

2024.12.13

Зуунмод

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт (Хүрсэн түвшин)		Гүйцэтгэлийн хувь
Зорилго: Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2, 3-р хуралдааны 01-р тогтоолоор баталсан “Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч, дотоодын үйлдвэрлэлийн худалдан авалтыг дэмжинэ”								
1.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, ил тод, тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулна.	ҮА-ны зардал	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	2 арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувь хангана.	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 2 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь
1.1.1	Төсвийн болон орон нутгийн төсөвт байгууллагын худалдан авалтыг зөвхөн www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулсан байна.	УТХО, ОНТ	Нийт зарласан тендер цахим тендерийн эзлэх хувь	100 хувь цахим тендер зарласан. (27 сумын ЗДТГ, 2 ОНӨААТҮГ, 12 төсөвт байгууллага)	100 хувь цахим тендер зарлана. (27 сумын ЗДТГ, 2 ОНӨААТҮГ, 12 төсөвт байгууллага)	Монгол Улсын 2024 оны төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулж, төрийн худалдан авах ажиллагааны цахим http://tender.gov.mn системд аймаг, сумдын болон орон нутгийн өмчит нийт 41 захиалагч, байгууллагаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчилж улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 241,588.5 сая, төгрөгийн 1477 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг цахим системд бүртгэсэн. Үүнд:		90%

						1.Захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолд зааснаар 20.0 сая буюу түүнээс доош төсөвт өртөгтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг “шууд худалдан авах” аргаар зохион байгуулах 9,569.6 сая, төгрөгийн 841 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр; 2.Төсөвт өртгийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй тендер зарлах 232,018.9 сая, төгрөгийн 636 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр. Тайлант оны жилийн эцэст төлөвлөгөөнд батлагдсан 229,728.7 сая, төгрөгийн 1312 (шууд худалдан авалт-841 төсөл, арга хэмжээ, тендер зарласан-471 төсөл, арга хэмжээ) төсөл, арга хэмжээнд худалдан авалт хийгдсэн байна.		
1.1.2	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр, 2022 оны 381 дүгээр, 2023 оны 11 дугаар тогтоолыг хэрэгжүүлж төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч, дотоодын үйлдвэрлэлийн худалдан авалтыг дэмжинэ.	УТХО, ОНТ	Дотоодын худалдан авалтын дүн. сая,төг	2023 онд нийт 15,919.3 сая, төг-н худалдан авалт хийсэн. Дотоодын худалдан авалт 4,573.8 сая,төг	1,900 сая, төг-н дотоодын худалдан авалт хийнэ.	Төрийн худалдан авах ажиллагааны цахим http://tender.gov.mn системээр дамжуулан Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа, үйлчилгээнд 2024 оны жилийн эцэст хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр аймгийн хэмжээнд эрүүл мэндийн төв, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн хоол, хүнсний материал худалдаж авах 5,530.0 сая, төгрөгийн сонгон шалгаруулалт зарлагдаж давхардсан тоогоор 285 иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авах тооцоотой байна.		100%
			Нийт тендерт орон нутгийн аж ахуйн нэгжийн	687 иргэн, аж ахуйн нэгж үүнээс 500 иргэн, аж ахуйн	80% нь орон нутгийн ААН бйана.			

			оролцооны хувь	нэгж орон нутгийнх		Тогтоолын хэрэгжилтийн тайлан мэдээллийг захиалагч байгууллагаас авч дуусаагүй, аймгийн нэгдсэн дүн мэдээг 2024.12.25-нд нэгтгэж дуусгахаар ажиллаж байна. 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уг арга хэмжээний зорилтод түвшинд бодлогын баримт бичиг (аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр)-т батлагдсанаар 1,900.0 сая, төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн буюу 2024 онд 5,530.0 сая, төгрөгийн худалдан авалт хийгдэнэ.		
Зорилго: Хоёр. Хууль, тогтоомжоор тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд								
2.1	Төрийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.	ҮА-ны төлөвлөлт	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	6 арга хэмжээний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувиар хангана.	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 6 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь
2.1.1	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч /өөрийн багц/-ийн худалдан авах ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системээр зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	УТХО, ОНТ	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, захиалагчийг томилж, хэрэгжилтийг 90-ээс дээш хувиар хангаж ажиллана.	2023 онд 18,967.5 сая,төг-н 74 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн. 18,592.5 сая,төг-н 70 төсөл, арга хэмжээнд тендер зарласан төлөвлөгөөний хэрэгжилтийг 96 хувьтай хангасан.	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг 90-ээс дээш хувь хангасан байна.	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч /өөрийн багц/-ийн 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж хэрэгжих 23,666.4 сая, төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 28,594.9 сая, төгрөгийн 142 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны А/01, А/551 дүгээр захирамжаар батлуулж, төрийн худалдан авах ажиллагааны цахим http://tender.gov.mn системд нийт 52,261.4 сая, төгрөгийн 160 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг бүртгэсэн. Үүнд: 1.Тендер шалгаруулалт зохион байгуулахгүй, шууд санхүүжилт олгохоор төлөвлөсөн 523.4 сая, төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ,		100%

						2.Тендер шалгаруулалт зохион байгуулах 51,737.9 сая, төгрөгийн 143 төсөл, арга хэмжээ байна. Тайлант оны жилийн эцэст улс, аймгийн хөрөнгө оруулалтын 48,748.1 сая, төгрөгийн 145 (шууд худалдан авалт-17 төсөл, арга хэмжээ, тендер зарласан-128 төсөл, арга хэмжээ) төсөл, арга хэмжээнд худалдан авалт хийгдсэн.		
2.1.2	Сумдын төсвийн захирагч нарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлж, цахим системд төсөл, арга хэмжээг батлаж, цахим тендер зарлаж, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	ОНТ	Төлөвлөгөөг цахим системээр баталж, хэрэгжилтийг 70-аас дээш хувиар хангаж ажиллана.	2023 онд 27 сумын төсвийн захирагч нийт тендер зарлах 35,318.2 сая,төг-н 423 төсөл, арга хэмжээг төлөвлөж, 30,131.9 сая,төг-н 339 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж, хэрэгжилтийг 80,14 хувь хангасан.	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг 70-аас дээш хувь хангасан байна.	Сумдын 2024 оны төсөвт тодотгол хийгдэж, 27 сумын захиалагч, байгууллагаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчилж улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 57,165.7 сая, төгрөгийн 1300 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг http://tender.gov.mn цахим системд бүртгэв. Үүнд: 1.Захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолд зааснаар 20.0 сая буюу түүнээс доош төсөвт өртөгтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг “шууд худалдан авах” аргаар зохион байгуулах 9,046.1 сая, төгрөгийн 824 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр; 2.Төсөвт өртгийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй тендер зарлах 48,119.5 сая, төгрөгийн 476 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр. Тайлант оны жилийн эцэст төлөвлөгөөнд батлагдсан 48,819.2 сая, төгрөгийн 1150 (шууд худалдан авалт-824 төсөл, арга хэмжээ, тендер зарласан-326 төсөл, арга хэмжээ) төсөл, арга		100%

						хэмжээнд худалдан авалт хийгдсэн байна.		
2.1.3	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч, өмчит газрын тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэхэд мэргэшлийн дамжлэг үзүүлэн ажиллана.	Төсөвт байгууллагын тухайн жилийн төсөв	Төсөвт болон өмчит байгууллагын ХАА-ны төлөвлөгөөг батлахад мэргэшил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.	2023 онд 13 байгууллага 136 төсөл, арга хэмжээнд 7,319.2 сая,төг-н бараа, ажил, үйлчилгээг бүртгэж, хэрэгжүүлж ажилласан.	Төсөвт байгууллагын төлөвлөгөөг батлахад мэргэшил, арга зүйн дамжлэг үзүүлсэн байна.	Тайлант онд төсөвт болон орон нутгийн өмчит 14 байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад нь мэргэшлийн зөвлөмж, чиглэл өгч төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд 6,738.1 сая, төгрөгийн 308 төсөл, арга хэмжээг бүртгэж. Үүнээс: 1.ТБОНӨХБАҮХАТХуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол төсөвт өртгийн дээд хязгаар “Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээ”-оор 20.0 сая, төгрөгөөс доош төсөвт өртөгтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг шууд худалдан авахаар 1,193.1 сая, төгрөгийн 292 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ; 2.Төсөвт өртгийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зарлах 5,544.7 сая, төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ тус тус төлөвлөгдсөн. 2024 оны жилийн эцэст тендер зарлавал зохих 16 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс 5,544.7 сая, төгрөгийн 16 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт зарласан байна.		100%
2.1.4	Ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс худалдан авах барааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.	ОНТ	ТБОНӨХБАҮХАТХ-н 44.2 дахь заалтыг хэрэгжүүлнэ	Аймгийн хэмжээнд 1,421.1 сая,төг-н 95 нэр төрлийн барааг төлөвлөж,	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Аймаг, сумын Засаг даргын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 543.9 сая, төгрөгийн 15 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөж, ерөнхий гэрээний цахим дэлгүүрээс 3 нэр төрлийн 217 ширхэг барааг 369.2 сая, төгрөгөөр худалдан авсан.		100%

				худалдан авсан.				
2.1.5	Аймаг, сум, төсөвт байгууллагын төсвийн захирагчдын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн Сангийн яам, холбогдох газруудад хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.	УТХО, ОНТ	Тайланг Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан хуулийн хугацаанд тайлагнана.	2023 оны тайланг нэгтгэн 2024 оны 1 дүгээр сарын 11-нд Сангийн яаманд тайлагнасан .	2024 оны тайланг 2025 оны 1 дүгээр сарын 15-наас өмнө тайлагнасан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдана авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр захиалагч байгууллагаас авч нэгтгэн тайлагнахаар ажиллаж байна. Тайланг нэгтгэхээр аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/2047, 01/2048 дугаар албан бичгийн сумын Засаг дарга, төсөвт байгууллага, орон нутгийн өмчит байгууллагад хүргэж, тайлан гаргахтай холбоотой зааварчилгааг 2024 оны 12 дугаар сарын 06, 11-ны өдрүүдэд холбогдох албан хаагчдад өгч ажилласан.		100%
2.1.6	Үнэлгээний хороог ТБОНӨХБАҮХАТХуулийн 48, 50 дугаар зүйлд заасныг үндэслэн байгуулж үнэлгээний хорооны гишүүнээр “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-г гаргуулан авч	ҮА-ны төлөвлөлт	Аймаг, сум, төсөвт байгууллагуудад зохион байгуулагдаж буй тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний	2023 онд аймаг, сум, төсөвт байгууллагы н 416 төсөл, арга хэмжээнд нийт давхацсан тоогоор	1. Үнэлгээний хороо байгуулах бүрт мэдэгдэл, мэдүүлэг гаргуулан авч, цахим системд бүртгэн, зөрчил үүссэн тохиолдолд холбогдох шийдвэрийг гаргуулна. 2. Сум, төсөвт байгууллагад	Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт (27 суманд эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ хасагдаж) 2024 оны төсвийн жилд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 62 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТХуулийн хүрээнд зохион байгуулж ажиллав. Аймгийн Засаг даргын захирамжаар нийт 54 үнэлгээний хороо байгуулагдаж, давхардсан тоогоор 310 албан		100%

	http://meduuleg.iaac.mn/AOS цахим системд бүртгэж хяналт, тавьж ажиллана.		хороо байгуулах тухай бүрт гишүүдээс мэдэгдэл, гаргуулж цахим системд бүртгэсэн байна.	2080 албан хаагч томилогдон ажилласан.	үнэлгээний хорооны гишүүдээс мэдэгдлийг заавал гаргуулан, https://meduuleg.iaac.mn/AOS тухай бүр бүртгэх талаар зөвлөмж, хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.	хаагчид томилогдон ажиллаж Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын дагуу Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх 310 мэдэгдэл гаргаж, Авлигтай тэмцэх газрын http://meduuleg.iaac.mn/AOS цахим системд бүртгэж баталгаажуулав. Энэ оны мэдэгдлийн хуудас, аймгийн Засаг даргын захирамж, холбогдох тендерийн баримт бичгийг нэгтгэн архивын нэгж үүсгэж ажиллав.		
--	---	--	--	--	---	---	--	--

Зорилго: Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд

3.1	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын дагуу үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлнэ.	АҮ-ны зардал	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	6 арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувь хангана.	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 7 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь
3.1.1	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn систем, аймгийн цахим хуудаст, бусад мэдээллийн хэрэгслэлээр нийтэд ил тод, нийтлэнэ.	ҮА-ны зардал	Нийтэд ил тод мэдээлсэн мэдээллийн тоо	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд нийтлэн ажилласан.	Хуулийн хэрэгжилтийг хангаж батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгон ажиллана.	Аймгийн Засаг даргын 2024 оны А/01, А/551 дүгээр захирамжаар Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөөг баталж, батлагдсан төсөвт өртөг 28,594.9 сая төгрөгийн 142 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд бүртгэж, батлагдсан төлөвлөгөөг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн		100%

						хурлын www.khural.mn , аймгийн Засаг даргын Тамгын газрын www.tov.gov.mn вэб хуудаст тус тус нийтэлж ил тод байдлыг хангаж ажиллаа.		
3.1.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер шалгаруулалтын мэдээлэл, гүйцэтгэлийн тайлан мэдээллийг ил болгож иргэд, олон нийтэд хяналт тавих, мэдээллээр хангаж ажиллана.	ҮА-ны зардал	Шилэн дансанд мэдээлсэн мэдээний тоо	Аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны хэрэгжилт, зохион байгуулалтын мэдээллийг тогтмол www.shilendans.gov.mn вэб хуудаст нийтлэн ажилласан.	ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны мэдээ, хэрэгжилтийн явц, тайланг шилэн дансанд мэдээлсэн байна.	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын мэдээлэл, хяналт шалгалт хийгдсэн аудитын дүгнэлт зэрэг 3 төрлийн мэдээллийг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу http://shilendans.gov.mn системд байршуулж, мэдээллээр хангаж ажиллав.		100%
3.1.3	Аймгийн Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг аймгийн вэб хуудаст нийтлэнэ.	ҮА-ны зардал	Нийтэд ил тод мэдээлсэн мэдээллийн тоо	Аймгийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг www.to.gov.mn вэб хуудаст нийтлэн ажилласан.	2023 оны аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтийг аймгийн вэб хуудаст нийтлэж, иргэд, олон нийтэд ил болгон ажиллана.	Төв аймгийн цахим хуудсанд 10 нэр төрлийн цэс үүсгэн мэдээллүүдийг тогтмол баяжилт хийж ажиллав. Үүнд: 1. Танилцуулга, мэдээлэл, 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 3. Тайлан, 4. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, 5. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулах журам, 6. Тендер шалгаруулалтын үр дүн, гомдлын мэдээ, 7. Хууль, эрх зүй, 8. Ил тод байдал (хүний нөөц, ёс зүй, авилга), 9. Шилэн данс, 10. Бусад мэдээ, мэдээлэл, 2024 оны байдлаар 65 удаагийн 30 гаруй мэдээлэл мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулж ажилласан. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан		100%

						авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын мэдээлэл, хяналт шалгалт хийгдсэн аудитын дүгнэлт зэрэг 3 төрлийн мэдээллийг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу http://shilendans.gov.mn системд мэдээлж ажиллав.		
3.1.4	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрээр улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, явцыг тухай бүр ил тод мэдээлнэ.	УТХО	Тендер шалгаруулалтыг хуулийн дагуу цахим системээр зохион байгуулж, явцын мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн байна.	2023 онд БШУЯамнаас 500.0 сая, төг-н 1 төсөл, арга хэмжээний эрх шилжин ирж цахим системээр тендерийг зарлаж, тендерийн үр дүн, гэрээний мэдээллийг нийтэд ил мэдээлж ажилласан.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдаж эрх шилжиж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийг хуулийн дагуу цахим системээр зохион байгуулж, нийтэд ил тод мэдээллэж ажиллана.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоол болон БХБЯам, БШУЯам, СОЯам, ЗТХЯам, ЭХЯам, ЭМЯам, ХХААХҮЯам, БОАЖЯамдын төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймгийн Засаг даргад 23,666.4 сая, төгрөгийн 18 төсөл арга хэмжээний эрх шилжиж, худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж байна. Үүнд: 1.Тендер шалгаруулалтын үр дүнгээр 19,724.6 сая, төгрөгийн гэрээг 16 ажилд байгуулсан, 2.Тендер зарласан нээлт хийгдэхээр хүлээгдэж буй 2,978.0 сая, төгрөгийн 2 ажил байна. Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр http://tender.gov.mn системд нийтлэж, ил тод мэдээллэж ажилласан.		100%
3.1.5	Худалдан авах ажиллагаанд захиалагч, тендерт оролцогч болон бусад холбогдох этгээдээс зөрчил гаргасан бол холбогдох хяналт шалгалтыг хийлгүүлэх чиглэлээр Сангийн яамны Худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хүргүүлж, хамтран ажиллана.	ҮА-ны зардал	Үнэлгээний хороо: Тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журмын дагуу зохион байгуулах; Тендерт оролцогч: Илт	2023 онд 1 компани тендерт оролцохдоо илтэд хуурамч материалтай оролцсон улсын байцаагчид	ТБОНӨХБАҮХАТХууль, холбогдох журмыг хэрэгжүүлэн ажиллана.	Тайлант оны жилийн эцэст аймгийн Худалдан авах ажиллагааны газарт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 40,179.7 сая, төгрөгийн 71 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж, тендер зарлах хугацаанд захиалагч болон тендерт оролцогчдоос илтэд гаргасан зөрчил тогтоогдоогүй байна.		100%

			хуурамч материалтай оролцсон, тендерт оролцогчийн холбогдох материалыг УБайцаагчид хүргүүлж ажилласан байна.	хянуулж эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн.			
3.1.6	ТБОНӨХБАҮХАТХуулийн 5 дугаар зүйл “Худалдан авах ажиллагааны зарчим 5.1.Өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана” гэсний дагуу тендерт оролцохыг сонирхсон этгээдэд тендерийн урилга, баримт бичиг, зураг-төсөв, батлагдсан техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын мэдээллийг цахим системд нийтлэж, тендерийн нээлтийг цахимаар зохион байгуулж, оролцсон аж ахуйн нэгж, иргэнд шалгарсан эсхүл шалгараагүй шалтгаан, нөхцлийг албан бичгээр хүргүүлж, үнэлгээний хорооны хурал, хурлын тэмдэглэл, зөвлөмж, захиалагч байгууллагын шийдвэр, тендерийн үр дүн, гэрээ, бараа, ажил,	ҮА-ны зардал	Хууль, журмын зүйл, заалт бүрийг хангаж ажилласан байна.	2023 онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөн өөс 70 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж давхацсан тоогоор 350 албан хаагч үнэлгээний хороонд ажиллаж, 241 аж ахуйн нэгж тендерт оролцсон. Тендерт оролцогчдод цахим	Хууль, журмын дагуу зохион байгуулж, нийтэд ил тод мэдээллэх тендерийн урилга, ТББичиг, зураг-төсөв, батлагдсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, тендерийн үр дүн, шалгарсан оролцогчтой байгуулсан гэрээ, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж, бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэж дууссан акт, баримт бичгийг www.tender.gov.mn системд тухай бүрт нь бүртгэж ажиллана.	Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийгдэж тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн өөрийн багцын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт төсөл, хөтөлбөр тусгагдаж төрийн худалдан авах ажиллагааны цахим http://tender.gov.mn системд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 52,261.4 сая, төгрөгийн 160 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ батлагдсан. Үүнд: 1.Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах 51,737.9 сая, төгрөгийн 143 төсөл, арга хэмжээ; 2.Шууд санхүүжилт олгож хэрэгжүүлэх 523.4 сая, төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ тус тус батлагдсан. Тайлант онд тендер шалгаруулалт зохион байгуулвал зохих ажлаас 48,227.7 сая, төгрөгийн 128 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны цахим http://tender.gov.mn системээр зарласан. Зарлагдсан 128 төсөл, арга хэмжээний тендерт үнэлгээний хороо (нэг үнэлгээний хороонд	100%

	үйлчилгээ хүлээлгэн өгсөн тухай акт, баримтыг цахим системд нийтлэнэ.			системээр дамжуулан тендерийн үр дүнг, гэрээний мэдээллийг системд бүрэн бүртгэж ажилласан.		дунджаар 5 гишүүнтэй байхаар) аймаг, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон)-г байгуулахад давхацсан тоогоор 640 албан хаагч томилогдож, тендерийн баримт бичиг, зураг-төсөв, техникийн болон ажлын даалгавар, тоо хэмжээ зэргийг цахим системд бүртгэж, нийтэд ил тод байршуулж ажилласан ба нийт давхацсан тоогоор 383 иргэн, аж ахуй эрхлэгч тендерт оролцсон байна. Тендерт оролцогчдийн шалгарсан болон шалгараагүй эсэх захиалагчийн шийдвэрийг цахим системээр дамжуулан хүргэж, тендерийн үр дүнг, гэрээний хамт тухай бүр төрийн худалдан авах ажиллагааны цахим http://tender.gov.mn системд бүртгэн оруулж иргэн, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, хяналт шалгалтын байгууллагад хөндлөнгийн хяналт тавьж ажиллах боломжийг олгож, тендер шалгаруулалтыг нээлттэй, ил тод зохион байгуулж ажиллав.		
3.1.7	Байгууллагын авлигын эрсэг үйл ажиллагааг төлөвлөж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд тайлагнана.	ҮА-ны зардал	Хууль, тогтоомжийг мөрдөж ажилласан байна.	-	100%	Байгууллагын авлигын эрсэг үйл ажиллагааг 2024 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд 1 зорилт 7 арга хэмжээтэй төлөвлөн газрын даргын тушаалаар батлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилээр 90% хувь, жилийн эцсээр 100% гүйцэтгэж		100%

						биелэлтийг хангаж ажилласан. ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд тайлагнах төрийн захиргааны хоёр, төрийн үйлчилгээний нэг албан хаагч нийт 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим системд бүртгэн баталгаажуулж ажиллав..		
Зорилго: Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд								
4.1	Төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, үнэлгээний хорооны гишүүдэд орон зайнаас үл хамааран тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлж, мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлнэ.	ҮА-ны зардал	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	8 арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувь хангана.	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 8 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь
4.1.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах байгууллагын ажилтнуудыг худалдан авах ажиллагааны чиглэлээр тогтмол зөвлөмж, чиглэл өгөх болон сургалт, мэдээллээр хангаж ажиллана.	-	-	-	Хамрагдсан сургалтын тоо	Тайлант онд төсөвт болон орон нутгийн өмчит 14 байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад нь мэргэшлийн зөвлөмж, чиглэл өгч төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд 6,738.1 сая, төгрөгийн 308 төсөл, арга хэмжээг бүртгэж. Үүнээс: 1.ТБОНӨХБАҮХАТХуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол төсөвт өртгийн дээд хязгаар “Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээ”-оор 20.0 сая, төгрөгөөс доош төсөвт өртөгтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг шууд худалдан авахаар 1,193.1 сая, төгрөгийн 292 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ; 2.Төсөвт өртгийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй Төрийн		100%

						худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зарлах 5,544.7 сая, төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ тус тус төлөвлөгдсөн. 2024 оны жилийн эцэст тендер зарлавал зохих 16 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс 5,544.7 сая, төгрөгийн 16 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт зарласан байна.		
4.1.2	Шинээр батлагдсан хууль, холбогдох журмын хүрээнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэших АЗ сертификатын сургалтыг зохион байгуулна.	ҮА-ны зардал	АЗ гэрчилгээтэй хүний тоо	2023 онд 186 албан хаагч АЗ гэрчилгээтэй болсон.	100%	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын болон худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэших үнэлгээний хороонд ажиллах АЗ гэрчилгээний сургалтыг 2024 оны 3 дугаар сард 15 байгууллагын 30 албан хаагчдад танхимаар зохион байгуулж, шалгалтанд 9 байгууллагын 11 албан хаагч АЗ гэрчилгээтэй болсон буюу сургалтанд хамрагдсан нийт албан хаагчдын 37 хувь нь амжилттай суралцаж, худалдан авах ажиллагааны хүний нөөцийг нэмэгдүүлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн нийт 197 албан хаагчийн нөөцийг бүрдүүлээд байна.		100%
4.1.3	Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд 2024 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцын мэдээлэл, танилцуулга хийх	ҮА-ны зардал	Худалдан авах ажиллагааны явц, мэдээллийг тогтмол өгч, ажиллана.	-	100%	Аймгийн 2024 оны худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд хуваарьт хугацаанд (5 удаагийн) танилцуулж, зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу барилга байгууламжийг барих, засварлах технологийн хугацаа дууссантай холбоотойгоор тендер зарлаагүй, гэрээ байгуулагдаагүй төсөл, арга		100%

						хэмжээний хөрөнгийг татан төвлөрүүлэхийг мэдэгдэж, гэрээ байгуулан гүйцэтгүүлж эхэлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг чанартай хийж дуусгах чиглэлийг аймгийн Засаг даргаас 2024 оны 01/1799 албан бичгийг сумдад хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллав.		
4.1.4	Сумдын Засаг даргын орлогч, үнэлгээний хороонд томилогдсон албан хаагч, иргэний төлөөлөлд сургалт зохион байгуулна.	ҮА-ны зардал	Сургалтанд хамрагдсан хүний тоо	2023 онд нийт 8 удаагийн 72 цагийн сургалт хийж давхацсан тоогоор 162 албан хаагчдыг хамруулж ажилласан.	100%	Улс, аймгийн 2024 оны төсөв батлагдсантай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 8.5.4-т заасан хугацаанд сумд 2024 оны төсөв батлахтай холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын 08-нд сумын ИТХурлын дарга, нарийн бичгийн дарга, Засаг дарга, орлогч, Санхүү албаны дарга нарт төсөв батлагдахад худалдан авах ажиллагааны төлөвлөлтөд анхаарах асуудлаар цахим уулзалт зохион байгуулсан. 2024 оны 1 дүгээр сард сумдын Засаг даргын орлогч, Санхүү албаныханд 2024 оны сумын Засаг даргын Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлахад анхаарах зөвлөмж, сургалт, мэдээ мэдээллийг цахимаар өгч ажилласан. 2024 оны 2 дугаар сард сумын Засаг даргын орлогч, үнэлгээний хороонд ажиллах албан хаагчдад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн, тендер шалгаруулалтын тендерийн баримт бичиг боловсруулах, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар бэлтгэх аргачлал, тендер үнэлэхэд анхаарах чиглэлээр цахим сургалт зохион байгуулж ажилласан.		100%

						Захиалагч байгууллага, үнэлгээний хороо, хорооны нарийн бичиг, гишүүдээс гарсан худалдан авах ажиллагаатай холбогдох асуудалд тухай бүр мэргэшлийн зөвлөгөө өгч ажилласан.		
4.1.5	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж батлагдсан хуваарийн дагуу зөвлөн туслах чиглэлээр орон нутагт ажиллана.	ҮА-ны зардал	Сум, төсөвт болон өмчит байгууллагад худалдан авах ажиллагааны чиглэлээр зөвлөн туслана.	2023 онд төсөвт 10, өмчит 3 байгууллагад зөвлөн туслаж ажилласан.	Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу зөвлөн туслах чиглэлээр ажиллана.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны Нэгдсэн төлөвлөгөө, Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан зөвлөн туслах ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/273 дугаар захирамжаар батлуулж, 2024 оны 9 дүгээр сард Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Өндөрширээт сумдад худалдан авах ажиллагааны талаар зөвлөн туслах, мэргэшил арга зүйгээр хангаж ажилласан.		100%
4.1.6	Байгууллагын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн программ unelgee.tov.gov.mn цахим систем нэвтрүүлж холбогдох тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг сар улиралаар тайлагнан ажиллана.	ҮА-ны зардал	Тайлангийн нэгдсэн платформ-д холбогдсон байна.	-	-	Худалдан авах ажиллагааны газар нь http://unelgee.tov.gov.mn цахим системд 2024 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн 14, захиргааны байгууллагын үйл ажиллагаа 33 нийт 47 заалтын хэрэгжилтийг хангаж, үр дүнг үнэлгээний нэгдсэн программ unelgee.tov.gov.mn цахим системд тогтмол тайлагнан ажилласан. Үүнд: Хууль, тогтоомж тогтоол шийдвэр 19, аймгийн ИТХТ-ын 10 тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын 13, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2, аймгийн нэгдсэн төлөвлөгөөний 1, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө 2 заалтуудыг тайлагнан ажиллаж байна. жилийн		100%

						эцсээр тайлагнавал 98.36 хувьтайгаар хэрэгжилтийг хангаж ажилласан.		
4.1.7	Байгууллагын нийт төрийн жинхэн албаны болон үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана.	ҮА-ны зардал	Гэрээ байгуулсан албан хаагчийн тоо	-	Нийт албан хаагчдийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувиар	Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргаас байгууллагын төрийн жинхэнэ албаны 7 албан хаагчидтай гүйцэтгэлийн, үйлчилгээний 3 албан хаагчидтай үйл ажиллагааны төлөвлөгөө, нийт албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж хэрэгжилт, үр дүнг улирал бүр тооцон хагас бүтэн жилээр үр дүнгийн урамшуулал тооцон ажилласан. 2024 оны жилийн эцэст 6 албан хаагчид 6.4 сая төгрөгийн урамшуулалыг хууль тогтоомжийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнтэй нь уялдуулан олгосон.		100%
4.1.8	Худалдан авах ажиллагааны газрын албан ёсны вэб хуудсыг шинээр хийлгэж, байгууллагын үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээлж ажиллана.	ҮА-ны зардал	Албан ёсны Веб хуудас, мэдээ мэдээллийн Facebook page хөтлөн ажилсан байна.	-	-	Үндэсний Дата төв УТҮГ-тай гэрээ байгуулан http://to.spa.gov.mn байгууллагын албан ёсны домайн хаягийг бий болгож, вэб хуудсыг хөгжүүлэлтийг хийж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар цахим хуудсанд нийтдээ 60 гаруй мэдээллийг орууллаа. Мөн аймгийн худалдан авах үйл ажиллагааны явцын мэдээллийг 10 хоног тутамд шинэчлэн боловсруулж байгууллагын вэб хуудас,Төв аймгийн албан ёсны цахим хуудаст байршуулав. 2024 онд байгууллагын цахим хуудсанд 3711 хандалт, 1005 шинэ хэрэглэгчид хүрч, нийт 220 мин 50 сек хугацаанд хандаж мэдээлэл авсан байна.		90%

Зорилго: Тав. Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах

5.1.	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт (танхим болон зайн, урт болон богино хугацааны)-д хамруулна.	ҮА-зардал	Хамрагдсан албан хаагч, тоо	2 албан хаагч мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан	8 арга хэмжээг 100%	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 8 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь
5.1.1	“Шинэ ажилтныг туршилтын хугацаанд чиглүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд дадлагажуулах зорилгоор шавилан сургана.	-	Хөтөлбөрт хамрагдсан албан хаагч, тоо	-	Хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагчийг дадлагажуулан ажилсан байна.	“Шинэ ажилтныг туршилтын хугацаанд чиглүүлэх хөтөлбөр”-н хүрээнд Худалдан авах ажиллагааны газрын Архив бичиг хэргийн ажилтан Б.Ууганбаяр, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Ариун-Уянга нарыг дадлагажуулах зорилгоор тус газрын ахлах мэргэжилтэн А.Зориггоо, Хуулийн мэргэжилтэн Б.Болдбаяр нар чиглүүлэгчээр ажиллаж, ажлын байран дээрх сургалт, зөвлөмж, чиглэлд арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Хөтөлбөрийн эхний шатны хүрээнд Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан” мэргэшил олгох сургалтанд Б.Ууганбаярыг 2024 оны 2/17-03/17 хооронд 1 сарын хугацаанд, Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Г.Ариун-Уянгыг худалдан авах ажиллагааны мэргэшлсэн ажилтны АЗ сургалтад хамруулж, мэргэшсэн ажилтны эрх авсан. Мөн 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан Төв аймаг дахь Монгол хэлний салбар бодлогын зөвлөл, Насан туршын суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулж буй “Монгол бичиг”-ын вакумжуулсан		100%

						сургалтанд архив бичиг хэргийн ажилтан Б.Ууганбаярыг хамруулан суралцуулсан.		
5.1.2	Хүний нөөцийн цахим систем, төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлт, хүний нөөцийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, тайлагнах	ҮА-зардал	Төрийн болон үйлчилгээний албан хаагч нэг бүрээр	Төрийн жинхэн албан хаагч 3, үйлчилгээний 2 албан хаагч	Нийт батлагдсан орон тоогоор төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлт хийгдсэн байна.	Төрийн албаны хүний нөөцийн удирдлага мэдээллийн төв "ХНУМТ"- цахим системд аймгийн худалдан авах ажиллагааны газрын төрийн захиргааны 7, үйлчилгээний 3 нийт 10 ажилтан албан хаагчийн мэдээллийг үнэн зөв бүрэн оруулж, төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, цалин, нэмэгдэл, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлт, хүний нөөцийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, тайлагнан ажилласан. Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 150 дугаар албан бичгийн дагуу газрын 2024 оны жилийн эцсийн мэдээ тайлан, холбогдох судалгааг тайлагнан ажиллав.		100%
5.1.3	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, хүний эрх, жендерийн боловсрол олгох ажлын хүрээнд төрийн албан хаагчийг Жендерийн анхан болон ахисан түвшний сургалтад (сертификаттай) хамруулна.	-	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	2 оос доошгүй албан хаагчийг сургалтад хамруулсан байна.	Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/18 дугаар тушаалаар байгууллагын Жендер, хүний эрхийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө нийт 5 арга хэмжээтэйгээр төлөвлөж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, хүний эрх, жендерийн боловсрол олгох ажлын хүрээнд жендерийн анхан шатны цахим сургалтад байгууллагын нийт 9 албан хаагч, аймгийн жендерийн салбар хорооноос агентлаг байгууллагын жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүдийг чадавхжуулах танхимын болон цахим хосолсон		100%

						сургалтад 2 албан хаагч хамрагдаж. Аймгийн Залуучууд хөгжлийн төв хамтран “Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төлөвлөгөө 12 бичил төсөл” чадвахжуулах сургалтанд 8 албан хаагч хамрагдсан.		
5.1.4	Урианы жилийн ажлын хүрээнд байгууллагын “Залуучуудын хөгжлийн зөвлөл” байгуулж залуучуудын манлайлал, үйл ажиллагаа идэвхи оролцоог нэмэгдүүлнэ.	-	Зөвлөл байгуулагдсан байна.	-	Залуучуудын хөгжлийн зөвлөл” байгуулж залуучуудын манлайлал, үйл ажиллагаа идэвхи оролцоо нэмэгдсэн байна.	Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/17дугаар тушаалаар байгууллагын "Залуучуудын хөгжлийн зөвлөл"-ийг байгуулж, зөвлөлийн дүрэм, 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлав. Төлөвлөгөөнд нийт 8 арга хэмжээг тусган жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүллээ. Үүнд:1.Залуучуудын хөгжил оролцоог хангах чиглэлээр улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан танхимын сургалт, хэлэлцүүлэгт 13, цахим сургалт хэлэлцүүлэгт 36 удаа, үндэсний чуулганд тус тус оролцож, орон нутаг, байгууллагын санал, дүгнэлтийг хүргүүлж, албан хаагчдаа хамруулав. Нийгмийн оролцооны ажлын хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран Зуунмод сумын “Баатрууд цэцэрлэгт хүрээлэн”-д мод тарьж, тус цэцэрлэгт хүрээлэн орчим нийтийн цэвэрлэгээ зохион байгуулав. Байгууллагын эцэг эхийн болон залуучуудын зөвлөл хамтран албан хаагчдын хүүхдүүдэд нийтийн үзвэр жүжиг үзүүлж, гэр бүлийн болоод		100%

						байгууллагын хамтын эерэг хандлагыг соёлын бүтээлээр дамжуулан бэхжүүлэх ажлыг зохион байгуулав. Мөн албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, орчны тохижилтыг сайжруулах чиглэлээр Зуунмод цэцэрлэжүүлэгт ОНӨҮГ-тай хамтран тасалгааны ногоон тохижилтыг хийж гүйцэтгэлээ. Албан хаагчдын тасралтгүй сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, хөгжлийн цагийг бий болгож Баасан гараг бүр хувь хүний хөгжил, Монгол бичгийн цахим хичээлийг зохион байгуулж хэвшүүллээ.		
5.1.5	Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр тодорхой заалтуудыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгуулж, түүнтэй холбоотой гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих.	ҮА-ны зардал	-	-	-	Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д ажил олгогчийн эрх үүргийн талаар заалт, арга хэмжээг өөрчлөн найруулж тусгаж ажиллав. 2024 онд ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой гомдол ирээгүй болно.		100%

5.1.6	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтээр	-	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдсан байна. Хэрэгжилтийн хувиар	Төрийн албан хаагчдын ажиллах таатай нөхцөл, ажлын байрны шаардлага стандартыг хангахуйц тохилог орчныг бүрдүүлж 6,1 сая төгрөг зарцуулж аж ахуйн аргаар өөрийн албан хаагчдийн хүч хөдөлмөрөөр засварлаж тохижуулав. Мөн зарим ашиглалтаас гарсан, эвдэрсэн муудсан компьютер тоног төхөөрөмж техник хэрэгслийг шинэчилсэн, байгууллагын онцлог (тендер шалгаруулалт, үнэлгээний хороо хуралдах) үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах 39,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинээр авч хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3- дахь заалтыг хэрэгжүүлж ТЗАХаагчдад олгох урамшуулалыг журмын дагуу шаардлага хангасан 3 албан хаагчид 17,9 сая төгрөгийг олгосон.		90%
5.1.7	Төрийн албан хаагчийг эрүүл мэндийн үзлэг шилжилгээнд бүрэн хамруулна.	-	Үзлэгт хамрагдсан Албан хаагчдын тоогоор	-	Бүрэн хамрагдсан байна.	Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оноос эхлэн аймгийн Засаг даргын шийдвэрээр 2024 оноос эхлэн шинэ бүтэц, орон тоотойгоор нийт 10 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд эрүүл мэндийн үзлэгт байгууллагын нэг албан хаагч Улаанбаатар хотод, 9 албан хаагч аймгийн эрүүл мэндийг дэмжих төвд үзлэг шинжилгээг хамрагдсан.		100%
5.1.8	Төрийн албан хаагчийн тэтгэмж, урамшуулал, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, бусад зардал, сургалт, хөгжлийн	ҮА-зардал	Хууль журамаар зохицуулсан зохих нэмэгдэл	-	Төсөвт тусгаж шийдвэрлэсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд “Худалдан авах ажиллагааны газар”-тай байхаар шийдвэрлэн хууль тогтоомж, зохих		100%

	асуудалтай холбоотой зардлын тооцоо, төсвийг тухайн жилийн төсвийн төсөлд тусгах санал боловсруулах, хууль тогтоомжийн болзол, шаардлага хангасан төрийн жинхэн албан хаагчдад зэрэг дэв олгуулах ажлыг зохион байгуулна.		урамшуулал олгогдсон байна.			журмын дагуу албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг аймгийн Засаг дарга нарт даалгасан. Чиглэл болгосоны дагуу Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар захирамжаар “Худалдан авах ажиллагааны газрын дүрэм, бүтэц орон тоо” баталж төрийн захиргаа (ТЗ)-ын 7, төрийн үйлчилгээ (ТҮ)-ний 3, нийт 10 орон тооны дээд хязгаартай ажиллахаар зохион байгуулсан. 2024 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр байгууллагын нийт батлагдсан төсөв 315.01 сая төгрөг, урсгал зардалд 264.02 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд: МУ-ын Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын төрийн захиргааны албан хаагчдад олгох урамшуулалд 17,1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс , албан хаагчдад үр дүнгийн урамшуулалд 3,2 сая төгрөг, үндсэн болон цалин хөлс нэмэгдэлд 173.11 сая төгрөг тус тус олгогдсон. Улсын их хурлын 2019 оны 21 тогтоолын хэрэгжилтийг хангасан төрийн захиргааны 5 албан хаагчийн нэмэгдэл, хуулиар олгогдвол зохих бусад нэмэгдлийг цахим системүүдэд мэдээллийг бүртгэн журмын дагуу хугацаанд нь олгож байна. Байгууллагын 2025 оны төсвийн төслийг боловсруулж аймгийн ЗДТГазрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд нь хүргүүлж ажиллав.		
Зорилго: Зургаа. Төсвийг төлөвлөж, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, байгууллагын үйл ажиллагааг ил тод болгож, хяналт тавих, төсвийг үр ашигтай зарцуулах гүйцэтгэлийг тайлагнах								
6.1.	2024 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарьт оруулан батлуулах	ҮА-ны зардал	Төсвийн хууль тогтоомжийг мөрдөж	-	5 арга хэмжээний	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 5 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь

			ажилласан байна.					
6.1.1	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнах	ҮА-ны зардал	Мэдээ тайлан сар 12 удаа тайлагнах	12	12	Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийн зарцуулалтын сарын хуваарийг баталж, гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж, хуулийн хугацаанд хянуулан ажиллав. Энэ оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 95% хувьтай байна.		100%
6.1.2	Байгууллагын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлаж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлан, мэдээг шилэн дансны цахим хуудаст нийтлэж ажиллана.	ҮА-ны зардал	Мэдээ мэдээллийн тоогоор	-	Зарцуулалт, гүйцэтгэл, тайлан, мэдээг шилэн дансны цахим хуудаст нийтлэгдсэн байна.	Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийн зарцуулалтын мэдээг шилэн дансанд байршуулж, хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдлыг хангуулж, олон нийтэд мэдээлж ажиллав.		100%
6.1.3	Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ыг томилон ажиллуулж шинээр авсан болон шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэлжүүлж няглан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу байгууллагын блансд тусгуулан ажиллана.	-	Зөвлөл байгуулагдаж үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.	-	-	Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг баталж 2024 оны өөрчлөн байгуулагдсан болон худалдан авалт хийгдсэн тоног төхөөрөмжийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгийн балансд бүртгэж, анхан шатны баримт, бүрдлийг хангаж ажиллав.		100%
6.1.4	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсөв, төсвийн төсөв, төсвийн	ҮА-ны зардал	Мэдээ мэдээлэл ифографик	-	24	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Шилэн дансны хуулиар байгууллагын хэмжээнд нийт 159		90%

	зарцуулалтын тайлан, мэдээг тогтмол иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллэнэ.		мэдээллийн тоогоор			мэдээ, мэдээлэлийг хуулийн хугацаанд оруулахаас 135 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлэгдсэн.		
6.1.5	2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хуулийн хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох тооцоо, судалгааг хийх нэгтгүүлнэ.	ҮА-ны зардал	-	-	-	2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл саналаа хуулийн хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж аймгийн 2025 оны төсвийн төсөлд нэгтгүүлж ажиллав.		100%
Зорилго: Долоо. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээ								
7.1.	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх, Үндэсний Монгол хэл, бичгээ хичээнгүйлэн суралцаж, хэрэглэж хэвших	ҮА-ны зардал	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо, хос бичгээр хөтөлсөн ажлыг үзүүлэлт	-	Хэрэгжүүлэх арга хэмжээний нийт хэрэгжлтийн хувиар	Хэрэгжилт (Хүрсэн түвшин) 2 арга хэмжээ		Гүйцэтгэлийн хувь
7.1.1	“Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая-2024” аян өрнүүлэн, төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулна.	ҮА-ны зардал	Аян зарлаж, байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусган шат дараатай арга хэмжээ төлөвлөсөн байна. Албан хаагчдийн оролцоо идэвхи	-	Аян зарлаж тусгайлсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж ажилласан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоол, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-д 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, бэлтгэлийг бүрэн хангах зорилтын хүрээнд 2024 оноос бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Үүнд: 1. Компьютер, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, монгол бичгээр албан бичиг хөтлөх		100%

					программ хангамжийг татаж суулган бэлтгэв. 2. Байгууллагын гадна болон дотор хаягийг кирилл болон монгол бичгээр стандартад нийцүүлэн байршуулсан. 3. Худалдан авах ажиллагааны газрын албан бичгийн хэвлэмэл хуудсыг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн Төрийн архивын тасгаар хянуулан батлуулж, монгол бичгээр хөрвүүлэн хэвлүүлж бэлэн болгосон. туршилтаар 11 албан бичиг бэлтгэн ажиллалаа. 4. Аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол бичгээр албан хэрэг хөтлөх стандартын танилцуулах сургалт”-д байгууллагын дарга болон архив, бичиг хэргийн ажилтны хамт хамрагдсан. Архив, бичиг хэргийн ажилтан нь Төрийн архивын тасаг, Насан туршийн суралцахуйн төв хамтран зохион байгуулж буй Монгол бичгийн 1 сарын вакумжуулсан сургалтад 2024.11.25-ны өдрөөс эхлэн 10 удаа хамрагдлаа. 5. ТЖАХ болон ТҮАХ-дын дунд монгол бичгийн түвшин тогтоох шалгалт, судалгаанд 3 удаа байгууллагын нийт ажилтан албан хаагчид бүрэн хамрагдаад байна. Аймгийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай” А/18 тоот тушаалаар байгууллагын хэмжээнд		
--	--	--	--	--	--	--	--

						үндэсний бичгээ сурах өдрийг бий болгов. Мөн тушаалын хамт албан хаагчид монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэх төлөвлөгөө батлан хүлээгдэж буй гүйцэтгэлээр хэрэгжилт, үр дүнг тооцохоор төлөвлөөд байна.		
7.1.2	Байгууллагын сургалтын төлөвлөгөө батлан гаргаж хэрэгжүүлж ажиллана.	-	Төлөвлөгөө батлагдсан байна.	-	Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллана.	Байгууллагын төрийн албан хаагчдийн мэргэшүүлэх сургалт хөгжлийн төлөвлөгөөг 8 арга хэмжээтэйгээр төлөвлөж газрын даргын 2024 оны 03 сарын 20-ны өдрийн А/08 тушаалаар батлан, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр бүрэн хангаж ажилласан.		100%

Хэрэгжилт тооцсон:

Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Ганхуяг